

Монгол Улсад даатгалын зах зээл үүсэж хөгжсөний 85 жилийн ой, банкнаас бусад санхүүгийн салбарыг зохицуулагч байгууллага үүсэж хөгжсөний 25 жилийн ойн хүрээнд санхүү, бизнес, эдийн засгийн чиглэлийн оюутан, судлаачдын дунд Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах гэж байна.

ЗОРИЛГО

Санхүү, бизнес, эдийн засгийн чиглэлийн оюутан, судлаачдын судалгаа хийх чадварыг дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлж, санхүүгийн байгууллагын талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд оршино.



Эрдэм шинжилгээний бага хуралд оролцохоор сонирхож буй оюутан, судлаачид 3 сэдвийн хүрээнд судалгааны ажлыг туурвина.

Бүтээлийн сэдэв **Даатгал, Хөрөнгийн зах зээл, Бичил санхүүгийн зах зээлийг хамарна.**



- Банкнаас бусад санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, арга зам
- Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх боломж, тулгамдаж буй асуудал
- Банкнаас бусад санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын эрсдэл даах чадвар, эрсдэлийг урьдчилан тооцох аргачлал

СУДЛААЧ

- 1-р байр – Өргөмжлөл, 2 000 000 /Хоёр сая төгрөг/
- 2-р байр – Өргөмжлөл, 1 500 000 /Нэг сая таван зуун мянган төгрөг/
- 3-р байр – Өргөмжлөл, 1 000 000 /Нэг сая төгрөг/



ОЮУТАН

- 1-р байр – Өргөмжлөл, 1 000 000 /Нэг сая төгрөг/
- 2-р байр – Өргөмжлөл, 700 000 /Долоон зуун мянган төгрөг/
- 3-р байр – Өргөмжлөл, 500 000 /Таван зуун мянган төгрөг/

БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА


2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 18.00 цаг хүртэл бүтээлийг хэвлэмэл болон электрон хэлбэрээр Санхүүгийн зохицуулах хорооны 405 тоот өрөө болон rsa@frc.mn хаягаар хүлээн авна.

ШАЛГАРУУЛАЛТ

Судалгааны ажилтай танилцан, үнэлэлт өгч оюутны ангилалд 6, судлаачийн ангилалд 6 ажлыг 2 дугаар шатанд сонгон шалгаруулна.

Эхний шатнаас шалгарсан судалгааны ажлуудыг 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр буюу Мягмар гарагт мэдэгдэх бөгөөд, шалгарсан оролцогчид 11 дүгээр сарын 15-ны өдөр танилцуулна.

Шагналт байруудад шалгарсан оролцогчдын шагналыг Санхүүгийн зохицуулагч байгууллага үүсэж хөгжсөний 25 жилийн ойн баярын арга хэмжээний үеэр гардуулна.



Шалгарсан бүтээлүүдийг Санхүүгийн зохицуулах хорооноос эрхлэн гаргадаг "Хүртээмжтэй санхүү" сэтгүүл болон албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.

